Сэтгэлийн шалтгаант архины хамаарлын эмнэлзүйн тохиолдол

Э.Бат-эрдэнэ[1,2], Ж.Чимэгсайхан[1,2], Д.Оюунсүрэн[1], Н.Билгүүн[2], З.Хишигсүрэн[1]

[1]АШУҮИС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
[2]Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
Цахим шуудан: gabibaterdene0327@gmail.com, Утас: 99797879

Түлхүүр үг:

Стресс
Хүчирхийлэл
Согтууруулах ундааны хэрэглээ
Сэтгэцийн эмгэг
Ялган оношлох

Товч утга

Үндэслэл: Сэтгэцийн эмгэг судлалд стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг буюу сэтгэлийн шалтгаанаар үүсгэгдсэн сэтгэцийн бүлэг эмгэг байх бөгөөд үүнийг мөн завсрын эмгэг хэмээн нэрлэдэг. Сэтгэцийн эмгэг үүсэх шалтгааны талаас нь авч үзвэл стресс нь биемахбодын болон сэтгэцийн олон эмгэг үүсэх, өвчин сэдрэх шалтгаан болдог. Хүн амын дунд зонхилон тохиолдох эмгэгийн тоонд архины хамаарал, сэтгэлийн шалтгаант эмгэг нь аль аль нь орох боловч стрессийн улмаас согтууруулах ундааны хэрэглээ ихэсч хосолсон эмгэг илэрсэн тул эмч эмнэлгийн мэргэжилтэнд оношлогоо, ялган оношлогоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой хэмээн үзэж энэхүү тохиолдлыг сонголоо. **Зорилго:** Сэтгэлийн шалтгаант эмгэг, архины хэрэглээтэй холбоотой эмгэгийг ялган оношлох, эмчилгээг төлөвлөх. **Зорилт:** Эмчлүүлэгчийн сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгийн эмнэлзүйг тогтоон оношийг баталгаажуулах, архины хэрэглээний түвшинг тогтоон, сэтгэлийн шалтгаант эмгэг, архины хамаарлын харилцан хамаарлыг судлахад оршино. **Тохиолдлын танилцуулга:** Уг тохиолдлыг эрдэм шинжилгээний ажлын зорилгоор ашиглах зөвшөөрлийг эмчлүүлэгчээс авсан болно. Эмчлүүлэгч 40 настай эмэгтэй. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн стационарт 4 дэх удаагаа хэвтэн эмчлүүлж байна. Зовуурь: Өөрийн үгээр: Нойр муу, сэтгэл санаа тавгүй, заримдаа үхмээр санагдана. Байн байн санаа алдмаар санагдаж, хоолонд дургүй. Сүүлийн хагас жилд 10 гаруй кг турсан. Сэтгэл санаа тавгүй үедээ гэртээ архи бага хэмжээгээр уудаг гэнэ. **Нөхрийн үгээр:** Сүүлийн үед ааш зан нь эвдрээд уур уцаар ихтэй, гэртээ ганцаараа архи ууна. Гэр бүлдээ анхаарал халамж тавих нь муудсан. Нойр муутай. Намайг их хардаад, солиороод байна гэх. **Хуучин түүхийн баяжилтаас үзвэл:** 2018 оноос 2022 оны 11-р сар хүртэлх хугацаанд сэтгэлийн шалтгаант дасан зохицохуйн эмгэг, хий үзэгдэлт дэмийрлийн шизофрени, архины шалтаант солио, сэтгэл гутрал-сэтгэл түгшилтийн хамшинж зэрэг оношоор хэвтэн эмчлүүлсэн байна. Өвчин эхэлсэнээс хойш сэтгэл түгших, биемахбодод эвгүй мэдрэмж төрж зовууртай байсан учраас зүрхний цахилгаан бичлэг, тархины MPI, дотор эрхтэний ЭХО шинжилгээ, бамбай булчирхай, хөхний ЭХО зэрэг шинжилгээнүүдийг өгсөн боловч ямар нэг өөрчлөлт илрээгүй. Дотрын эмч болон найзынхаа зөвлөснөөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтээд биеийн байдал сайжирч байсан. Сүүлийн 3 удаагийн хэвтэлтэнд нөхөр цагдаа, түргэн дуудаад, намайг солиороод байна гээд эмнэлэгт хэвтүүлсэн хэмээн ярина. Сүүлийн хэвтэлтийн үеийн зовуурь: Нөхрийн үгээр: Уур ихтэй, архи нэхнэ, хүүхдүүдээ маш их загнана. Гэртээ орохгүй гээд байрны гадаа суугаад байхаар нь цагдаа дуудаад хэвтүүлсэн гэх. 4 дэх удаагийн хэвтэлтэнд архины шалтгаант хий үзэгдэл дэмийрэл гэсэн оношоор 21 хоног эмчлүүлээд гарсан байна. **Хэлцэмж:** Эмчлүүлэгч нь биемахбодын болон сэтгэл санааны зовуурийн улмаас багажийн шинжилгээг 2021 оны 6-дугаар сар, 2022 оны 10-дугаар сард хийлгэсэн боловч ямар нэгэн эмгэг тогтоогдоогүй бөгөөд сэтгэцийн эмнэлэгт хэвтэн сэтгэл санаа тайвшруулах, нойр сайжруулах, сэтгэц нөлөөт солиорын эсрэг эмүүдийг бага тунгаар эмчилгээнд хэрэглэхэд биеийн байдал сайжирч зовуурь шаналгаа багассанаас үзвэл сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгтэй болох нь тогтоогдож байна. Өөрөөр хэлбэл сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгийн үед вегетатив мэдрэлийн тогтолцооны хөөрлийн улмаас биемахбодын зовуурь буюу сэрэл мэдрэхүйн өөрчлөлт давамгайлсан синестопатийн шинжүүд илүүтэй илэрдэг боловч эдгээр зовуурь нь шинжилгээгээр батлагддаггүй онцлогтой. **Дүгнэлт:** Гэр бүлийн хүчирхийлэл нь хүчтэй стрессорын нэг хэлбэр бөгөөд стрессийг зохистой аргаар тайлаагүй тохиолдлууд нь согтууруулах ундааны хамааралд өртөхөд нөлөөлж байна. Эмчлүүлэгчид гэр бүлийн болон ганцаарчилсан сэтгэл засал, архины хамаарлаас гаргах эмчилгээ зайлшгүй шаардлагатай байна.

Үндэслэл: ДЭМБ-ын (WHO, 2022) тооцооллоор дэлхий дахинаа сэтгэцийн эмгэг бүхий 970 сая хүн амьдарч байгаа бөгөөд 8 хүн тутмын нэг нь сэтгэцийн эмгэгтэй гэж үзэж болохоор байна. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сэтгэцийн эмгэгүүдийн тоонд сэтгэл түгшилт, сэгэл гутрал, сэтгэлийн хөдөлгөөн цочирдлын эмгэг, сэтгэлийн гэмтлийн дараах хариу урвалууд орж байна.[1] Сэтгэцийн эмгэг үүсгэх гадаад шалтгааны нэг нь сэтгэлийн гэмтэл буюу стресс бөгөөд стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг үүсэхэд тухайн стресс үүсгэх хүчин зүйлийн хүч, үргэлжлэх хугацаа, хувь хүний сэтгэлзүйн онцлог нөлөөлнө гэж үздэг.[2] 2013 онд Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолдох эмгэгийн судалгаагаар сэтгэлийн шалтгаант сэтгэл түгших эмгэг хамгийн их (18.5%) тархалттай[3] болох нь тогтоогдсон бөгөөд СЭМҮТ-ийн 2021 оны статистикаас үзвэл хүн амын дунд тэргүүлэх эмгэгийн тоонд сэтгэцийн органик эмгэгүүд (24.7%) сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэг (22.1%), сэтгэц идэвхит бодисын шалтгаант сэтгэцийн эмгэг (19.3%) эзэлж байна.[4] Сэтгэц эмгэг судлалд сэтгэцийн өвчний суурин дээр архи, мансууруулах бодисыг хавсран хэрэглэхийг хосолсон оношлогоо хэмээн нэрлэдэг бөгөөд сэтгэцийн эмгэгтэй хүн архи, мансууруулах бодис хэрэглэх нь хувь хүний эрүүл мэнд, нийгэм, хөдөлмөрийн дасан зохицох чадварыг алдагдуулдаг.[5]

Уг эмнэлзүйн тохиолдлын хувьд сэтгэцийн эмнэлэгт 4 удаа хэвэтн эмчлүүлэсн боловч оношийн хувьд ялган оношлох шаардалгатай байсан тул сургалт, ялган оношлогооны зорилгоор сонгон эмч нарын эмнэлзүйн хэлэлцүүлэгт оруулсан тохиолдол болно.

Зорилго: Сэтгэлийн шалтгаант эмгэг, архины хэрэглээтэй холбоотой эмгэгийг ялган оношлох, эмчилгээг төлөвлөхөд оршино.

Зорилт:

1. Эмчлүүлэгчийн сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгийн эмнэлзүйг тогтоон оношийг баталгаажуулах, архины хэрэглээний түвшинг тогтоон оношлох
2. Сэтгэлийн шалтгаант эмгэг, архины хамаарлын харилцан хамаарлыг судлан тогтоож ялган оношлох, эмчилгээг төлөвлөхөд оршино.

Арга зүй: Уг тохиолдлыг эрдэм шинжилгээний ажлын зорилгоор ашиглах зөвшөөрлийг эмчлүүлэгчээс авсан болно.

Тохиолдлын танилцуулга: Эмчлүүлэгч 40 настай эмэгтэй. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн стационарт 4 дэх удаагаа хэвтэн эмчлүүлж байна.

Зовуурь: Өөрийн үгээр: Нойр муу, сэтгэл санаа тавгүй, заримдаа үхмээр санагдана. Байн байн санаа алдмаар санагдаж, хоолонд дургүй. Сүүлийн хагас жилд 10 гаруй кг турсан. Сэтгэл санаа тавгүй үедээ гэртээ архи бага хэмжээгээр уудаг гэнэ.

Нөхрийн үгээр: Сүүлийн үед ааш зан нь эвдрээд уур уцаар ихтэй, гэртээ ганцаараа архи ууна. Гэр бүлдээ анхаарал халамж тавих нь муудсан. Нойр муутай. Намайг их хардаад солиороод байна гэх

Амьдралын түүхээс: (Ээж болон өөрийн үгээр**)** Эцэг эхийн анхны охин, эрүүл гүйцэд төрж бага насны өсөлт хөгжилт хэвийн байсан. 6 дүүтэй учир эрх танхи зангүй, хичээл сурлагадаа сайн. Сургуульд тэргүүний сурагч, оюутны тоонд ордог, олон нийтийн ажилд сайн оролцдог. Онцгой авьяасгүй ч юм юманд эв дүйтэй байсан. 10 жилийн сургууль, дээд сургуулиа амжилттай төгсөж хувиараа удирдах түвшний ажил хийж байсан. Багадаа өвдөж байсан өвчин үгүй. Насанд хүрсэн үедээ халдварт шар өвчнөөр өвчилсөн, эрүү болон нүдний мэс засалд тус бүр 1 удаа орсон. Зан ааш төлөв, сэргэлэн цовоо, их хариуцлагатай, нямбай, олон найз нөхөдгүй, бусадтай санал бдолоо хуваалцахдаа жаахан тааруу хүүхэд байсан. Удамд ээж, аавын талд архи хэтрүүлэн хэрэглэдэг хүн байсан. Өөр сэтгэцийн эмгэгтэй хүн байгаагүй. 4 хүүхэд төрүүлсэн.

Осол, гэмтэл: 1 удаа автомашинд хөнгөн байдлаар шүргүүлсэн. Хүнд гэмтэл аваагүй боловч хүзүүний хэсгээр хэд хоног өвдсөн. Нөхөртөө зодуулсаны улмаас гоо сайхны мэс ажилбарт 1 удаа, эмэгтэйчүүдийн мэс засалд 1 удаа орсон.

Амьдралд нь тохиолдож байсан сэтгэлийн цохилт авсан үйл явдлууд:

- 2005 онд анх гэр бүл болж охин төрүүлсэн боловч нөхөр нь осолд орж нас барсан
- 2006 онд төрсөн дүүг нас барахад их цочирдсон
- 2008 онд дахин гэр бүл болсон. Нөхөр гэр бүл болсон цагаасаа эхлэн маш их харддаг, зоддог, утсыг нь шалгадаг, ажил хийлгэх дургүй, гэртээ хүүхдүүдээ хараад байхыг шаарддаг. Нөхөр нь согтууруулах ундаа хэрэглэж гэрээс гадуур хоноглоно, цалингаа гэр бүлдээ зарцуулдаггүй, гэр бүлийн гадуур харилцаатай олон хүн байсныг найз нөхөд болон ажлын газрынх нь хүмүүс хэлж, салахыг зөвлөж байсан гэх
- 2017 онд нөхөр нь эхнэртээ хэлэлгүйгээр найз эмэгтэйтэйгээ хамтран үл хөдлөх хөрөнгөө барьцаанд тавьсан
- Нөхөр нь өөрийн ах дүүс, ээжтэйгээ эхнэрээсээ илүү дотно харилцаатай, тэд нартаа илүү анхаарал хандуулдаг, ах дүүс нь эхнэрт нь таагүй ханддаг
- Байнгын хэрүүл маргаантай, нөхөртөө зодуулсны улмаас хэд хэдэн удаа гэмтлийн эмнэлэг болон хүчирхийллийн эсрэг төвд хандаж байсан.

Өвчний түүхээс: Өөрийн үгээр: Нөхрөө өөрт нь хэлэлгүй үл хөдлөх хөрөнгөө барьцаалсаныг мэдээд сэтгэл зовж, түгшиж эхэлсэн. Үүнээс хойш нойр муудаж, толгой өвдөх, цочромтгой болох, уур уцаартай болох, сэтгэл санаа тогворгүй болох шинжүүд 8-9 сар илэрсэн. Энэ хугацаанд дотрын, мэдрэлийн, уламжлалтын олон эмнэлэгт үзүүлж эмчилгээ хийлгэсэн боловч үр дүнгүй байсан учир бусад хүмүүсийн зөвлөснөөр сэтгэцийн эмнэлэгт 10 хоног эмчлэгдээд биеийн байдал сайжирсан. Нойр муудсанаас хойш нойроо хүргэх зорилгоор 50, 100 гр уудаг болсон. Ялангуяа хэрүүл маргаантай, сэтгэл санаа тавгүй үедээ архи уудаг. Гэхдээ олон хоног дараалж ууж байгаагүй, нэг удаад дээд тал нь 200-300 гр ууж байсан. Нойргүй байсан, сэтгэл санаа тавгүй,

нөхөртэйгөө хэрэлдэж маргалдсан сүүлийн 3-4 жилд ер нь бол тайвшрах гэж архи ууж байсан, гэхдээ би өөрийгөө архинд донтох өвчтэй болсон гэж хэлэхгүй гэнэ. Гэрээсээ гадуур, найз нөхөдтэйгөө уудаггүй. Олон хоног нойргүй үед харанхуй буланд байгаа зүйл, өлгүүртэй хувцас өөр зүйл болж харагдаад, энд тэнд юм хөдлөөд байгаа юм шиг санагдаж байсан тохиолдол бий. Дээрх зовууруудын улмаас сэтгэцийн эмнэлэгт 4 дэх удаагаа хэвтэн эмчлүүлж байна. Сүүлийн 2 удаагийн хэвтэлтэнд нөхөр жижигхэн шалтгаан гаргаж байгаад намайг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлээд байсан гэх.

Хуучин түүхийн баяжилтаас үзвэл: Сэтгэцийн эмнэлэгт 4 удаа, Наркологийн хувийн эмнэлэгт 1 удаа хэвтэн эмчлүүлсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үеийн оношийг авч үзвэл:

1. Дасан зохицохуйн эмгэг
2. Архины солио
3. Хий үзэгдэлт дэмийрлийн шизофрени
4. Архины шалтаант солио гэсэн оношт тавьсан байлаа.

Эмчлүүлэгчтэй ярилцахад: Өөрийн амьдрал, эрүүл мэнд, тулгамдсан асуудлын талаар нээлттэй ярьж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, өөртөө шүүмжлэлтэй хандана. Гэр бүл салах нөхцөл тулгарсан тул бусдын хараат бусаар амьдарч, ажилдаа орж, хүүхдүүдээ өсгөнө. Айдасгүйгээр нийгмийн харилцаанд ормоор байна гэх мэт цаашдын ажил, амьдралын зорилгын тухай ярьж нулимстайгаар уйлна.

Сэтгэцийн эмнэлэгт хэвтэх хугацаанд хийгдсэн шинжилгээ: Эмгэг сэтгэл судлалын шинжилгээнд: Ой тогтоолт, оюуны ажиллах чадварын бүтээц болон ерөнхийлөн дүгнэх чадвар сайн. Хувийн хандлага дагасан бодол санаа үүсэх хандлагатай. Сэтгэл санаа тайван бус тогтворгүй, өөрийн үнэлгээ дээшилсэн, аувь хүний сэтгэцийн чанарт хандах шүүмжлэлт чанар султай.

Архины хамаарлыг үнэлэх Мичиганы сорилд: 21 оноо.

Архины хараат байдлын II үе.

Дээрх эмнэлзүйн үзлэг, ярилцлага, объектив болон субъектив анамнези, шинжилгээний дүгнэлт, эмгэг сэтгэл судлалын шинжилгээнд тулгуурлан

Эмнэлзүйн үндсэн онош: F 43.2 Дасан зохицохуйн эмгэг

Дагалдах онош: Архины хараат байдал (Шинж тэмдгийн архидалт) оношийг тавьж эмчлүүлэгчид ганцаарчилсан болон гэр бүлийн сэтгэл засал эмчилгээ, архины хамаарлын эсрэг эмчилгээ, нойрсуулах, тайвшруулах бүлгийн сэтгэц нөлөөт эмийн эмчилгээ зөвлөн эмнэлгээс гаргасан болно.

Хэлцэмж: Энэхүү эмнэлзүйн тохиолдол нь гэр бүлийн тааламжгүй харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл, эмчлүүлэгчийн ойр дотны хүмүүс нас барсан зэрэг амьдралд тохиолдсон стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг болох сэтгэлийн хүчтэй стрестт өгөх хариу урвалын дасан зохицохуй алдагдах, сэтгэл гутралаар өгөх хариу урвал тод илэрсэн тохиолдол байв. Өвчний олон улсын ангилалаар уг хариу урвал нь сэтгэлийн цочирдолд өртсөнөөс хойш 2 жил буюу түүнээс удаан хугацаагаар ужиг байдлаар сэтгэлийн таагүй байдлын олон шинжүүдээр илэрдэг.[6] Иймд эмчлүүлэгч нь өөрт илэрсэн стрессийн шалтгаант вегетатив мэдрэлийн тогтолцооны цочрогдлын шинжүүдийн улмаас багажийн шинжилгээг 2 удаа хийлгэхэд эмгэг тогтоогдоогүй, сэтгэц нөлөөт эмийн эмчилгээнд засралын байдалд орж байсан нь сэтгэлийн шалтгаант эмгэг болохыг баталж байна.

Эмчлүүлэгч нь сэтгэл санааны хямралаа засахын тулд, нойроо сайжруулах гэсэн сэдлээр согтууруулах ундааг хэрэглэх болсон нь хүн амын дундах сэтгэцийн эмгэгийн талаарх буруу ойлголт, стресс тайлах ур чадвар дутмаг байгааг харуулж байна. Эмчлүүлэгчийн нөхөр гэр бүлийн асуудалтай, эхнэр нь хардсан тохиолдолд эхнэрээ хардаад, солиороод байна гэж эмчид мэдээлэх, эмчлүүлэгч өөрөө архины асуудалтай учраас зарим тохиолдолд хий үзэгдэл, дэмийрэл төст шинжүүд илэрч байсан[7] нь архины шалтгаант хардах дэмийрэл мөн эсэхийг нарийвчлан оношлох зайлшгүй шаардлагатай нөхцөлийг үүсгэж байлаа. Уг тохиолдолд стрессийн улмаас анхдагчаар сэтгэлийн гэмтлийн шалтгаант эмгэг үүсч, уг эмгэгийн суурин дээр архины зүй бус хэрэглээ үүссэн учир дагалдах оношийг архины хамаарал хэмээн тогтоосон. Түүнчлэн эмчлүүлэгч эмнэлэгт хэвтэх бүрт өөр өөр онош тавьсан байгаа нь нэг талаас сэтгэцийн эмгэг судлалд хамшинжийн онош тавьдагтай холбоотой байж болох хэдий ч нөгөө талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг тогтоох үзлэг хийх, амьдралын болон өвчний түүхийг цуглуулах, сэтгэц-биемахбодын талаас илрэх шинжүүдийн уялдаа холбоог тогтооход анхаарлаа сайн хандуулах нь эмчлүүлэгчийн оношийг зөв тогтоох, эмчилгээ, зөвлөгөө, мэдээллийг зөв чиглүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг илтгэсэн хэлэлцүүлэг болсон гэж үзлээ.

Хэвлэлийн тоймоос үзвэл хосолсон оноштой эмчлүүлэгчдийн эмчилгээний асуудал нь бэрхшээлтэй бөгөөд удаан хугацаанд хувьчилсан байдлаар эмийн болон эмийн бус, сэтгэл заслын эмчилгээ хийх шаардлагатай[8] гэсэнтэй санал нийлж байна.

Дүгнэлт: Гэр бүлийн хүчирхийлэл нь хүчтэй стрессорын нэг хэлбэр бөгөөд стрессийг зохистой аргаар тайлаагүй тохиолдлууд нь согтууруулах ундааны хамааралд ороход нөлөөлж байна.

Ном зүй:

1. *htpps://www.who.int/newsroom/fact sheets. Mental disorders. 8 June 2022*
2. *С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. УБ. 2017. х-588-590*
3. *Сэтгэцийн эрүүл мэндийн албаны 90 жилийн түүхэн замнал. УБ 2019. Х-14-*
4. *СЭМҮТ. Статистик үзүүлэлт-2017-2021. УБ. 2022. х 10-11*
5. *Анцыборов А.В, Дубатова И.В. Проблемы двойных диагнозов в психиатрии и наркологии: уходящая реальность или интеграции?. Медицина. DOI: 10.21661/r-486030*
6. *ДЭМБ: Өвчний олон улсын ангилал. Нэгдүгээр боть. УБ 2005.*
7. *Монгол дархь мэдрэл сэтгэцийн өвчний судалгаа. УБ.1969. х-51-54*
8. *T.M. Kelly, D.C.Daley. Integrated treatment of substance use and psychiatric disorders. Soc Work Public Health. 2013; 28:388–406.*

The case with stress-induced alcohol dependence

Bat-Erdene E[1,2], Chimegsaikhan J[1,2], Oyunsuren D[1], Bilguun N[2], Khishigsuren Z[1]

[1]Department of Mental Health, School of Medicine, MNUMS,
[2]National Center for Mental Health
E-mail: gabibaterdene0327@gmail.com, Tel: +976-99797879

Background: It is complicated to diagnose and treat cases with a combined diagnosis, where a case with a mental disorder, and dependent on alcohol and drugs.
Aim: To make a differential diagnosis and plan the treatment for stress-related disorders combined with alcohol consumption.
Objectives: To confirm the clinical diagnosis of mental disorder, which is caused by stress, to determine the level of alcohol consumption, and to detect the relationship between stress-related disorder and alcohol dependence.
Materials and methods: Permission to use all information for research purposes was obtained from the patient.
Case report: The patient is 40 years old, woman. She is hospitalized for the 4th time at the National Center of Mental Health. In the period from 2018 to November 2022, she was hospitalized 4 times with the diagnosis of stress-related adjustment disorder, paranoid schizophrenia, alcohol-induced delirium, and mixed anxiety-depressive syndrome. Since the beginning of the symptoms, she has been given analysis such as electrocardiogram, MRI of the brain, ultrasound of the internal organs, thyroid, and breast ultrasound, but no changes have been detected. In the psychiatric hospital were used low doses of sedatives, hypnotics, and antipsychotic drugs improved physical condition and decreased symptoms. Because each hospitalization had a different clinical diagnosis, it was selected for clinical discussion by psychiatrists for the purpose of differential diagnosis and treatment planning.
According to the anamnesis obtained from the patient and the patient's mother, the husband is a domestic abuser, and the woman was receiving aid from a trauma hospital and violence center due to being beaten by her husband and undergoing surgery.
When she tells about her husband's unstable in the family, he believes that she going crazy and following him, and her husband is interested in putting his wife in a psychiatric hospital.
The patient became addicted to alcohol after consuming alcoholic beverages in the last 4-5 years under the guise of improving her mood when she was worried about her life, had trouble sleeping, or suffered from violence.
Conclusion: Domestic violence is a form of strong stressor, and cases of inadequate stress relief contribute to the development of alcohol dependence. Family and individual psychotherapy and alcohol addiction treatment are essential for therapists.

Keywords: Stress, Violence, Alcohol consumption, Mental disorder, Differential diagnosis